



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/70

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн “Гурав” дахь хэсгийн 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын шилдэг шимтгэл төлөгч- ажил олгогчийг шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын дагуу шалгаруулалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Б.Батхуяг)-т үүрэг болгосугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Журам батлах тухай” А/492 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.ЗОРИГТ





ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИЛДЭГ ШИМТГЭЛ
ТӨЛӨГЧ-АЖИЛ ОЛГОГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-НДБХСГ- 02- 2017

Баталсан:	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын еरөнхий газрын дарга	Д.Зоригт
Хянасан:	Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга	 Ц.Ганцэцэг
Боловсруулсан:	Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газрын мэргэжилтэн	 Д.Нарантуяа

Эх хувь	Дардас
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	



Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
ЭМНДЕГ-ЫН НДБХСГ	...	2017-04-...	2017-04-...	5

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2013-12-04	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/492 дугаар тушаалыг үндэслэн	Б.Батжаргал
Хувилбар 2	2017-04-...	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/... дугаар тушаалыг үндэслэн	Д.Нарантуяа
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			



АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэх
6. Шалгуур үзүүлэлт
7. Шагнал урамшуулал
8. Шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогчийг сурталчлах



Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 01 дугаар сарын 25.-ны өдрийн A/70 дугаар тушаалын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИЛДЭГ ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ-АЖИЛ ОЛГОГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

Нийгмийн даатгалын тухай хуульд заасан үүргээ биелүүлж, ажилтнууд (албан хаагч)-аа нийгмийн даатгалд бүрэн хамруулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хугацаанд нь гаргаж, шимтгэлийг хуульд заасан хугацаанд бүрэн төлсөн, шимтгэлийн өргүй, хяналт, шалгалтаар төлбөр зөрчил гаргаагүй ажил олгогчийг “Нийгмийн даатгалын шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогч” (Цаашид “шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогч” гэх)-оор шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. Хамрах хүрээ

Нийгмийн даатгалын шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогчийг шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулах, нийтэд сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг үйл ажиллагааг хамарна.

ГУРАВ. Хамаарах талууд

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагууд

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэх

5.1. Шалгаруулалтыг дараах үе шаттай зохион байгуулна. Үүнд:

5.1.1. Аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь энэхүү журмын 3.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тус бүр 3 ажил олгогчийг шалгаруулж, шалгарсан ажил олгогчийн мэдээллийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газарт тайлан, холбогдох үзүүлэлтүүдийн хамт жил бүрийн 03 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.



5.1.2. Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар нь аймаг, дүүргийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн шалгаруулалтын баримт бичгийг хүлээн авч, нэгтгэн шалгуур үзүүлэлтийн дагуу “Нийгмийн даатгалын шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогч”-ийг шалгаруулж, Нийгмийн даатгалын алба үүсч, хөгжсөний ойн тэмдэглэлт өдөр улсын хэмжээнд зарлана.

ЗУРГАА. Шалгуур үзүүлэлт

6.1. Шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогчийг шалгаруулахдаа дараах үзүүлэлтийг харгалzan үзнэ. Үүнд:

6.1.1. Тайлант жилд нийгмийн даатгалын санд хамгийн их шимтгэл төлсөн;

6.1.2. Нийгмийн даатгалд хамгийн олон даатгуулагч хамруулсан;

6.1.3. Нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн жилд хугацаанд нь бүрэн төлж, жилийн турш өр үүсгээгүй;

6.1.4. Тухайн жилд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол гаргаагүй;

6.1.5. Тухайн жилд ажлын байрны тоогоо тогтвортой хадгалсан;

6.1.6. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хугацаанд нь гаргаж тайлагнаасан;

6.1.7. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, шимтгэл төлөлтөд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага болон холбогдох хяналтын байгууллагаас хийсэн хяналт, шалгалтаар төлбөр, зөрчил илрээгүй байх.

6.2. Тайлангийн жилд шинээр ажлын байр бий болгосон бол давуу тал болно.

ДОЛОО. Шагнал урамшуулалт

7.1. Улсын хэмжээнд жил бүр 15 шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогч (“Том” аж ахуйн нэгж, байгууллага, “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч” тус бүр 5)-ийг шалгаруулж, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлан Өргөмжлөл, дурсгалын цом олгоно.

7.2. Өмнөх санхүүгийн жилд шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогчоор шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага дараагийн жил дахин шалгарсан тохиолдолд “Батламж” олгож болно.



**НАЙМ. Шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогчийг сурталчлах**

8.1. Тухайн онд улсын хэмжээнд шалгарсан шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогчийн түгийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын гадна талбайд жилийн туршид хүндэтгэлтэйгээр байрлуулна.

8.2. Нийгмийн даатгалын шилдэг шимтгэл төлөгч-ажил олгогчийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан олон нийтэд мэдээлэх, тухайн ажил олгогчийн тэргүүн туршлагыг судлан үзүүлэх сургалт зохион байгуулна.

8.3. Ажил олгогч, даатгуулагчдыг нийгмийн даатгалын байгууллагаас нийгмийн даатгалын чиглэлээр зохион байгуулах зөвлөлдөх уулзалт, дотоодын сургалт, семинарт урьж оролцуулна.



---оо---